



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

**ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ, ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ**

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 7.1.6, Цагдаагийн албаны тухай хуулийн 93<sup>1</sup>.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн багийн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрийн 80 хувиар тогтоосугай.
- 2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан нөхөн төлбөрийн үлдэх 20 хувийг Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нарт үүрэг болгосугай.
- 3.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн багийн бие бүрэлдэхүүнд томилолтын зардлыг олгох ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн ерөнхий газар (Т.Сүхболд)-т даалгасугай.
- 4.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД О.АЛТАНГЭРЭЛ